

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2024/8/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Б.Долгорсүрэн Утас: 51-261885 Цахим хаяг: Dolgorsurenb@audit.gov.mn Ахлах аудитор: О.Баярмаа Утас:51-261628 Цахим хаяг: Bayarmaao@audit.gov.mn Аудитор: Ж.Бүжинханд Утас:51-261628 Цахим хаяг: Bujinlkhandj@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА Д.ДЭЛГЭРСАЙХАН
ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.03.25 № 04/817

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй 35,936.4 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Засгийн газрын 2023 оны 69 дүгээр тогтоолоор Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн дүрмийг баталж, компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 31,598.4 сая төгрөгөөр тодорхойлсон боловч нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй, хувь нийлүүлэх хөрөнгийн 51.0 хувь болох 16,115.2 сая төгрөгийн хөрөнгийг Улсын бүртгэлийн ерөнхий газраас шилжүүлэх талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэр гараагүй, 49 хувь болох 15,483.2 сая төгрөгийн хөрөнгийг Мигасон ХХК-аас хүлээлгэн өгсөн акт үйлдээгүй;

- Мигасон ХХК-ийн үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нийт 23,068.8 сая төгрөгийн хөрөнгийг түрээслэх гэрээг байгуулж, түрээсийн 2,618.0 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн;
- Тайлант хугацаанд нийт 12,299 ширхэг 480.8 сая төгрөгийн гадаад паспортын бэлдцийг техникийн алдаа гэж зарлага болгосон.

Дээр дурдсан зөрчлүүд нь Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д "Компанийн эд хөрөнгө нь эзэмшиж байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээс бүрдэх бөгөөд компани нь эдгээр бүх эд хөрөнгөөрөө хариуцлага хүлээнэ", 97 дугаар зүйлийн 97.2-т "Компани нь дараах баримт бичгийг хадгалж, хууль болон компанийн дүрэм, журмаар тогтоосон эрх бүхий этгээдийн шаардлагаар танилцуулах үүрэгтэй", 97.2.1-т "нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримт бичиг", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Улсын бүртгэлийн ерөнхий газрын хэвлэх үйлдвэрт үндэсний энгийн гадаад паспорт хэвлэж эхэлсэнтэй холбоотойгоор үндсэн үйл ажиллагааны орлого 21,047.1 сая төгрөгийг бүрдүүлж, улсын төсөвт, орон нутгийн тэмдэгтийн хураамж 6,455.9 сая төгрөг, торгуулийн 3.9 сая төгрөгийг тус тус орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлжээ.

Аудитын гол асуудал

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Ховд, Хэнтий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 7,578.9 сая төгрөгийн архив, конторын барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдөр гарч, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 45, 46 дугаар тогтоолоор 2024 онд үндсэн хөрөнгөд бүртгэх зөвшөөрөл олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 33 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 92.1 хувийн биелэлттэй гэж үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	13,809,951.2	21,783,334.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	120,435.9	622,881.8
33	АВЛАГА	835,265.5	644,737.6
34	УРЬДЧИЛГАА	3,789.1	1,042,235.0
35	БАРАА МАТЕРИАЛ	9,780,460.7	11,894,480.1
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	3,070,000.0	7,578,999.7
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	49,394,138.1	73,341,201.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	49,394,138.1	73,341,201.9
39200	Биет хөрөнгө	35,404,096.6	57,854,916.9
39300	Биет бус хөрөнгө	13,990,041.5	15,486,285.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	63,204,089.3	95,124,536.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	178,204.1	3,107,689.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	178,204.1	3,107,689.7
41300	Өглөг	84,211.5	2,646,136.7
41400	Урьдчилж орсон орлого	93,992.6	461,553.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	63,025,885.2	92,016,846.4
51	Засгийн газрын хувь оролцоо	63,025,885.2	92,016,846.4
51100	Засгийн газрын оруулсан капитал	12,211,503.2	12,211,503.2
51200	Хуримтлагдсан үр дүн	50,303,597.7	79,294,558.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	510,784.3	510,784.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	63,204,089.30	95,124,536.10

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	57,525,160.4	112,857,955.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	26,067,054.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	-	26,067,054.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18,196,749.0	25,654,790.2
120	Нийтлэг татварын бус орлого	18,196,749.0	25,654,790.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	39,328,411.4	61,136,110.3
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	42,983,025.9	83,561,671.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	42,983,025.9	83,561,671.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	41,444,516.0	82,660,426.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,460,178.1	26,616,576.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,161,605.3	3,588,172.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	897,025.2	1,072,046.4
2104	Хангамж, бараа материалын зардал	1,680,264.1	2,021,503.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	140,804.8	223,424.8
2107	Томилолт, зочны зардал	18,179.5	33,302.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,945,730.5	35,597,512.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,140,728.5	13,507,888.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,538,509.9	901,244.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	14,542,134.6	29,296,284.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,327,192.4	305,323.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	10,214,942.2	28,990,961.2

2.3 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	65,423,801.2	137,294,698.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	26,011,255.8	52,393,870.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	26,011,255.8	52,393,870.6
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	26,011,255.8	52,393,870.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	84,134.0	23,749,717.5
120	Нийтлэг татварын бус орлого	84,134.0	23,749,717.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	39,328,411.4	61,151,110.3
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	61,898,952.3	112,800,209.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	61,898,952.3	112,800,209.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	34,335,188.1	84,350,278.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,380,666.2	27,313,577.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,205,620.4	3,954,414.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	900,877.8	1,115,945.6
2104	Хангамж, бараа материалын зардал	869,014.9	19,855,117.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	703,297.9	210,498.3
2107	Томилолт, зочны зардал	18,179.5	33,302.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,544,170.5	29,892,247.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,713,361.0	1,975,175.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,563,764.2	28,449,931.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	3,524,848.9	24,494,488.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	4,297,426.5	23,912,653.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,297,426.5	23,912,653.1
2200	Дотоод эх үүсвэрээр	4,297,426.5	23,912,653.1
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(4,297,426.5)	(23,912,653.1)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	(79,389.7)
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-	79,389.7
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(772,577.6)	502,445.9
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	893,013.4	120,435.9
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	120,435.9	622,881.8

2.4 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	52,806,473.5	52,806,473.5
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	4,469.5	4,469.5
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	52,810,943.0	52,810,943.0
9	Тайлант үеийн үр дүн	10,214,942.2	10,214,942.2
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	63,025,885.2	63,025,885.2
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	63,025,885.2	63,025,885.2
19	Тайлант үеийн үр дүн	28,990,961.2	28,990,961.2
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	92,016,846.4	92,016,846.4

2.5 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	61,440,425,100.00	61,308,256,828.88	132,168,271.12	99.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	38,380,543,100.00	38,269,867,146.88	110,675,953.12	99.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	37,732,942,800.00	37,696,341,990.88	36,600,809.12	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	26,244,353,500.00	26,235,217,971.11	9,135,528.89	100.0
210101	Үндсэн цалин	18,572,214,700.00	17,069,543,562.53	1,502,671,137.47	91.9
210102	Нэмэгдэл	4,975,618,900.00	5,935,112,070.28	(959,493,170.28)	119.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,739,144,000.00	2,137,773,537.73	(398,629,537.73)	122.9
210104	Урамшуулал	957,375,900.00	1,092,462,991.57	(135,087,091.57)	114.1
210105	Гэрээт ажлын хөлс	-	325,809.00	(325,809.00)	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,670,158,600.00	3,660,486,474.57	9,672,125.43	99.7
210201	Тэтгэврийн даатгал	2,491,532,900.00	2,530,379,851.11	(38,846,951.11)	101.6
210202	Тэтгэмжийн даатгал	349,368,700.00	332,665,001.65	16,703,698.35	95.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	221,135,200.00	215,154,851.89	5,980,348.11	97.3
210204	Ажилгүйдлийн даатгал	55,283,700.00	52,219,090.55	3,064,609.45	94.5
210205	Эрүүл мэндийн даатгал	552,838,100.00	530,067,679.37	22,770,420.63	95.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,071,645,300.00	1,062,537,061.33	9,108,238.67	99.2
210301	Гэрэл, цахилгаан	271,908,100.00	247,239,481.39	24,668,618.61	90.9
210302	Түлш, халаалт	489,774,600.00	501,483,390.09	(11,708,790.09)	102.4
210303	Цэвэр, бохир ус	46,329,800.00	42,266,711.85	4,063,088.15	91.2
210304	Байрны түрээс	263,632,800.00	271,547,478.00	(7,914,678.00)	103.0
2104	Хангамж, бараа материалын зардал	796,692,200.00	792,446,490.86	4,245,709.14	99.5
210401	Бичиг хэрэг	429,853,700.00	435,627,135.83	(5,773,435.83)	101.3
210402	Тээвэр, шатахуун	79,610,900.00	79,567,488.00	43,412.00	99.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	118,097,800.00	109,475,957.03	8,621,842.97	92.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,581,000.00	10,734,500.00	(153,500.00)	101.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	158,548,800.00	157,041,410.00	1,507,390.00	99.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	716,655,400.00	715,234,141.00	1,421,259.00	99.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	75,368,900.00	75,132,080.00	236,820.00	99.7
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	14,059,000.00	13,525,800.00	533,200.00	96.2
210604	Урсгал засвар	627,227,500.00	626,576,261.00	651,239.00	99.9
2107	Томиллолт, зочны зардал	31,741,500.00	31,694,500.00	47,000.00	99.9
210702	Дотоод албан томиллолт	31,741,500.00	31,694,500.00	47,000.00	99.9

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,437,601,100.00	3,434,969,252.01	2,631,847.99	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,793,472,800.00	2,791,752,095.13	1,720,704.87	99.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	15,268,000.00	14,548,000.00	720,000.00	95.3
210803	Даатгалын үйлчилгээ	7,987,400.00	7,964,518.00	22,882.00	99.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,373,800.00	2,357,216.00	16,584.00	99.3
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	497,900.00	424,000.00	73,900.00	85.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	212,853,400.00	212,775,830.00	77,570.00	100.0
210807	Газрын төлбөр	4,534,100.00	4,533,900.00	200.00	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	400,613,700.00	400,613,692.88	7.12	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,764,095,200.00	1,763,756,100.00	339,100.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,713,356,100.00	1,713,347,000.00	9,100.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	50,739,100.00	50,409,100.00	330,000.00	99.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	647,600,300.00	573,525,156.00	74,075,144.00	88.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	647,600,300.00	573,525,156.00	74,075,144.00	88.6
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,000,000.00	8,000,000.00	0.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	497,724,700.00	425,838,744.00	71,885,956.00	85.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	141,875,600.00	139,686,412.00	2,189,188.00	98.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	23,059,882,000.00	23,038,389,682.00	21,492,318.00	99.9
220001	Барилга байгууламж	4,519,482,000.00	4,508,999,682.00	10,482,318.00	99.8
222001	Тоног төхөөрөмж	18,540,400,000.00	18,529,390,000.00	11,010,000.00	99.9
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	61,440,425,100.00	61,308,256,828.88	132,168,271.12	99.8
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	60,220,425,100.00	60,082,760,809.88	137,664,290.12	99.8
310001	Улсын төсвөөс санхүүжих	60,220,425,100.00	60,082,760,809.88	137,664,290.12	99.8
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,220,000,000.00	1,225,496,019.00	(5,496,019.00)	100.5
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,220,000,000.00	1,225,496,019.00	(5,496,019.00)	100.5
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	23	23	-	
610001	Төсвийн байгууллага	23	23	-	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	1,247.00	1,247.00	-	
620001	Удирдах ажилтан	40	40	-	
620002	Гүйцэтгэх ажилтан	1,062.00	1,062.00	-	
620003	Үйлчлэх ажилтан	145	145	-	

2.6 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	776,347,726.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	776,347,726.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	633,898,723.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	243,167,439.87
210101	Үндсэн цалин	-	34,732,137.46
210102	Нэмэгдэл	-	178,223,123.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	0
210104	Урамшуулал	-	5,472,249.37
210105	Гэрээт ажлын хөлс	-	24,739,929.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	33,914,448.64
210201	Тэтгэврийн даатгал	-	27,927,441.78
210202	Тэтгэмжийн даатгал	-	1,524,369.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	1,219,495.48
210204	Ажилгүйдлийн даатгал	-	296,081.86
210205	Эрүүл мэндийн даатгал	-	2,947,060.05
2104	Хангамж, бараа материалын зардал	-	10,718,280.00
210401	Бичиг хэрэг	-	2,005,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	4,648,980.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	4,064,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	39,569,680.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	18,820,000.00
210604	Урсгал засвар	-	20,749,680.00
2107	Томилолт, зочны зардал	-	1,608,000.00
210702	Дотоод албан томилолт	-	1,608,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	3,430,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	3,430,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	301,490,875.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	301,490,875.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	142,449,002.62
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	138,332,406.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	138,332,406.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	4,116,596.62
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	4,116,596.62
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	776,347,726.13
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	776,347,726.13
131103	ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	653,067,226.13
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	95,781,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	27,499,000.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 24 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 14 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгч, 10 байгууллагын санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн.

Аудитад хамрагдсан 14 харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 79,131.2 сая төгрөгийн 53 алдаа, зөрчил илэрснээс 195.2 сая төгрөгийн 12 алдаа¹ илэрснийг залруулж, 51.6 сая төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт тогтоож, 145.9 сая төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага хүргүүлж, 78,738.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах 27 зөвлөмжийг өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 35,936.4 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 35,463.3 сая төгрөгөөр давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

Үүнээс төсвийн төвлөрүүлэн захирагч:

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт нийт 78,779.3 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 10.3 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 49.9 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 148.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 албан шаардлагыг хүргүүлж, 78,571.1 сая төгрөгийн 14 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа:

- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайланд зардлыг 4.8 сая төгрөгөөр дутуу илэрхийлснээр татварын авлагыг 0.5 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
- Нэмэгдсэн өртгийн албан татварын авлагыг 9.6 сая төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Шатахууны картын үлдэгдэлд байгаа 0.2 сая төгрөгийг урьдчилж гарсан зардлаар тайлагнасан байна.

3.1 Төлбөрийн акт

1. Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК олон улсын үнэт цаасны үзэсгэлэнд оролцох эрх авахаар нэр бүхий албан хаагчид 28.0 сая төгрөгийг шилжүүлсэн боловч буцаан төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нэр бүхий албан тушаалтанд шилжүүлсэн 28.0 сая төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2. Тайлант онд Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК нэр бүхий 6 ажилтанд нийт 19.3 сая төгрөгийн, Улсын бүртгэлийн ерөнхий газар нэр бүхий 15 ажилтанд нийт 2.6 сая төгрөгийн, нийт 21.9 сая төгрөгийн цалинг илүү тооцож олгосон байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон 21.9 сая төгрөгийн цалинг алдаа гаргасан буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

Улсын бүртгэлийн ерөнхий газарт:

1. Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-аас худалдан авсан гадаад паспортын бэлдцээс 1,407.8 сая төгрөгийн төгрөгийн үнэ бүхий 20,116 ширхэг алдаатай бэлдцийн үлдэгдлийг үйлдвэрээс шалтгаалсан эсвэл техникийн алдаа эсэхийг хянаж шийдвэрлээгүй байна. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/08 дугаар тушаалаар Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн нийлүүлсэн хэвлэх машины тохируулга хийхэд ашигласан үндэсний энгийн гадаад паспортын бэлдцийг нягтлан шалгаж, техникийн дүгнэлт гаргах" ажлын хэсгийг байгуулсан боловч дүгнэлт гаргаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндэсний энгийн гадаад паспортын алдаатай бэлдцийг нягтлан шалгаж, техникийн дүгнэлт гаргуулаагүй зөрчлийг арилгаж, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага хүргүүлэв.

2. Улсын бүртгэлийн ерөнхий газар үндсэн үйл ажиллагааны зардлаас малчинд 7.5 сая төгрөгийн цалин олгож, ажил олгогчоос 0.9 сая төгрөгийн нийгмийн даатгалын зардалд төлж, нийт 8.4 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.1-т "төсвийн ерөнхийлөн захирагч урьдчилан бичгээр зөвшөөрсөн байх", 44.3-т "Үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагаанд зориулж шууд болон шууд бусаар хөрөнгө зарцуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагаанд зориулан төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг арилгаж, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага хүргүүлэв.

3. Улсын бүртгэлийн ерөнхий газар баталсан төсвөөс 3.5 сая төгрөгийг тэмцээний шагналд, 6.9 сая төгрөгийг биеийн тамирын хувцас худалдан авахад, 10.1 сая төгрөгийг хоол, бусад зардалд, нийт 20.5 сая төгрөгийг спортын арга хэмжээнд зориулалт бусаар зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:", 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолын 6-д "улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр, ялангуяа төсвийн нэмэлт орлого, хандив болон тусламжийн орлогоор гадаад, дотоодын тойрон аялал, зугаалга, ой

тэмдэглэх арга хэмжээ, урлагийн наадам, уралдаан тэмцээн зохион байгуулахгүй байх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг арилгаж, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-д:

4. Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК Смарт карт ХХК-тай 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдөр 2 сарын хугацаатай байгуулсан "Гадаад паспортын хэвлэх машины хор болон хорны сав, дагалдах хэрэгсэл нийлүүлэх гэрээ"-ний хэрэгжилтийг дүгнэж баталгаажуулахгүйгээр 102.0 сая төгрөгийн үлдэгдэл санхүүжилтийг бүрэн шилжүүлж, зарлагаар тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Гадаад паспортын хэвлэх машины хор, хорны сав, дагалдах хэрэгсэл нийлүүлэх гэрээний 3-т "Энэхүү гэрээний хугацаа нь 2023 оны 10 сарын 30-ны өдрөөс 2023 оны 12 сарын 30-ны өдрийг дуустал хоёр сарын хугацаатай байх ба гэрээний 4.1.3-д заасан бараа нийлүүлэлтийн хуваарийн дагуу захиалагчид барааг хүлээлгэж өгнө" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Гадаад паспортын хэвлэх машины хор, хорны сав, дагалдах хэрэгсэл нийлүүлэх гэрээг дүгнээгүй, хөрөнгийг хүлээн аваагүй зөрчлийг арилгаж, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага хүргүүлэв.

5. Улсын бүртгэлийн ерөнхий газар баталсан төсвөөс 3.5 сая төгрөгийг тэмцээний шагналд, 6.9 сая төгрөгийг биеийн тамирын хувцас худалдан авахад, 10.1 сая төгрөгийг хоол, бусад зардалд, нийт 20.5 сая төгрөгийг спортын арга хэмжээнд зориулалт бусаар зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:", 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолын 6-д "улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр, ялангуяа төсвийн нэмэлт орлого, хандив болон тусламжийн орлогоор гадаад, дотоодын тойрон аялал, зугаалга, ой тэмдэглэх арга хэмжээ, урлагийн наадам, уралдаан тэмцээн зохион байгуулахгүй байх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг арилгаж, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Улсын бүртгэлийн ерөнхий газарт:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1. Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 1,168.5 сая төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 1,125.2 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 351.6 сая төгрөгийн тавилга, 27.0 сая төгрөгийн эд хогшил, 273.3 сая төгрөгийн бусад үндсэн хөрөнгө,

программ хангамж, нийт 2,945.8 сая төгрөгийн 421 нэр төрлийн 1324 ширхэг үндсэн хөрөнгө үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дугаар тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7.1-т "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэж, холбогдох байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлэх.

2. Арилжааны банкны данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 2. Голомт банкны 3 дансны "Арилжааны банканд данс нээх зөвшөөрлийн гэрээ"-ний хугацаа дууссан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3-т "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банканд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ.", 35.4-т "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бичгээр ирүүлсэн зөвшөөрөлгүйгээр банк аливаа төсвийн байгууллагад данс нээхийг хориглоно.", Данс автоматжуулах үйлчилгээ үзүүлэх гэрээний 2.1-т "Энэхүү гэрээ нь 2017 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс 2018 оны 04 дүгээр сарын 04 дүгээр сарын 11-ний өдрийг хүртэл 1 /нэг/ жилийн (хуанлийн) хугацаанд хүчин төгөлдөр байна." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зөвшөөрөлгүй эзэмшиж байгаа Голомт банкны 3 дансыг цаашид ашиглах эсэх талаар холбогдох байгууллагад хандаж шийдвэрлэх.

3. Нягтлан бодох бүртгэл, тооцоотой холбоотой асуудал

Илрүүлэлт 3. Гадаад паспортыг анх болон давтан авсан, хугацаа дууссан, үрэгдүүлсэн, гэмтээсэн, хэдэн ширхэг хэвлүүлснийг бүртгэлийн цахим сүлжээнээс санхүүгийн тайланд татан авч тооцоо бодох боломжгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7-т "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бүртгэлийн цахим системээс гадаад паспортын хэвлүүлсэн зориулалтын төрлийг татаж авч, тооцоо бодох боломжийг бүрдүүлэх.

4. Төсвийн үр ашигтай холбоотой асуудал

Илрүүлэлт 4. Тайлант хугацаанд нийт 12299 ширхэг 480.8 сая төгрөгийн гадаад паспортын бэлдцийг техникийн алдаа гэж зарлага болгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны

өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг үр ашигтай, үр дүнтэй зарцуулж, бэлдцийн алдааг гаргахгүй байх арга хэмжээг авч ажиллах.

5. Нягтлан бодох бүртгэл, тооцоотой холбоотой асуудал

Илрүүлэлт 5. Татварын цахим системийн тодорхойлолтоор 9,568.0 сая төгрөгийн өр төлбөр, авлагын үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татварын цахим системийн өр төлбөр, авлагын зөрүүг арилгаж, тайлагнах.

6. Нягтлан бодох бүртгэл, тооцоотой холбоотой асуудал

Илрүүлэлт 6. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны А-1/2489 дугаар албан бичгээр Улсын бүртгэлийн ерөнхий газрын биет бус хөрөнгөнд бүртгэлтэй 859 м.кв талбай бүхий нэгж талбараас 402 м.кв талбай бүхий газар эзэмших эрхийг салган Арьсны өвчин судлалын үндэсний төвд шилжүүлэн эзэмшүүлэх зөвшөөрлийг олгосон боловч нягтлан бодох бүртгэлээс хасаагүй, өөрчлөгдсөн газрын гэрчилгээ, кадастрын зургийг гаргуулаагүй байна.

Энэ нь Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-т "газар дээрх үл хөдлөх хөрөнгө нь тухайн газрын бүрдэл хэсэг байх", 27 дугаар зүйлийн 27.2-т "Газар эзэмших эрхийн гэрчилгээг зөвхөн Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгоно", 27.4-т "Хүчин төгөлдөр эрхийн гэрчилгээгүй аливаа этгээд газар эзэмшихийг хориглоно", 47 дугаар зүйлийн 47.1-д "Газар эзэмших, ашиглах эрх дуусгавар болоход хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол уг газар дээрх барилга байгууламж, бусад эд хөрөнгө өмчлөгч этгээдийн тэрхүү эд хөрөнгөө тухайн газар дээр ашиглах эрх дуусгавар болно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Газрын кадастрын зургийг гаргуулан, газар эзэмших эрхийн гэрчилгээг авч, нягтлан бодох бүртгэлд тайлагнах.

Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-д:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 7. Засгийн газрын 2023 оны 69 дүгээр тогтоолоор Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн дүрмийг баталж, компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 31,598.4 сая төгрөгөөр тодорхойлсон боловч нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй. Хувь нийлүүлсэн хөрөнгийн 51 хувь болох 16,115.2 сая төгрөгийн хөрөнгийг Улсын бүртгэлийн ерөнхий газраас шилжүүлэх талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэр гараагүй, 49 хувь болох 15,483.2 сая төгрөгийн хөрөнгийг Мигасон ХХК-аас хүлээлгэн өгсөн акт үйлдээгүй, тус компанийн 23,068.8 сая төгрөгийн хөрөнгийг үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглаж байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.-д "Компанийн эд хөрөнгө нь эзэмшиж байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээс бүрдэх бөгөөд компани нь эдгээр бүх эд хөрөнгөөрөө хариуцлага хүлээнэ", 30 дугаар зүйлийн 30.5-т "Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг компанийн дүрэмд тусгасан байна", 30.1-т "Тухайн компаниас хувьцаа эзэмшигчдэд эзэмшүүлсэн буюу гаргасан нийт давуу эрхийн болон энгийн хувьцааны

нэрлэсэн үнийн дүнг компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө гэх бөгөөд компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд тухайн компанийн зарласан болон эргүүлэн худалдаж авсан халаасны хувьцаа хамаарахгүй", 97 дугаар зүйлийн 97.2-т "Компани нь дараах баримт бичгийг хадгалж, хууль болон компанийн дүрэм, журмаар тогтоосон эрх бүхий этгээдийн шаардлагаар танилцуулах үүрэгтэй", 97.2.1-т "нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримт бичиг" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хувь нийлүүлсэн хөрөнгийг хүлээн авах арга хэмжээг авч, нягтлан бодох бүртгэлд бүртгэх.

2. Хөрөнгийн гэрээ, өглөгийн тооцоотой холбоотой асуудал

Илрүүлэлт 8. Мигасон ХХК-ийн хувь нийлүүлсэн 49 хувь болох 15,483.2 сая төгрөгийн хөрөнгө нь тодорхойгүй байхад Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, тус компанийн гүйцэтгэх захиралтай үйл ажиллагаанд ашиглаж байгаа нийт 23,068.8 сая төгрөгийн хөрөнгийг түрээслэх гэрээг байгуулж, түрээсийн 2,618.0 сая төгрөгийн өр төлбөрийг тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн дүрмийн 15.4-д "Компанийн санхүүгийн чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ", 15.4.3-д "хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үйл ажиллагаанд ашиглаж байгаа нийт хөрөнгөнөөс тооцоолсон хөрөнгө түрээслэх гэрээг ТУЗ-ийн хурлаар дахин хэлэлцүүлж, шийдвэр гаргуулах.

3. Урьдчилж гарсан зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт 9. Тайлант оны эцэст байгууллагын харилцахаас үндэсний цахим болон энгийн гадаад паспортын түүхий эд материал худалдан авах 1,042.2 сая төгрөгийн зардлыг урьдчилж шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын хөрөнгийг зохистой удирдаж, өр, авлага үүсгэхгүй байх.

4. Шатахууны бүртгэл, жолоочийн тооцоотой холбоотой асуудал

Илрүүлэлт 10. Улсын бүртгэлийн ерөнхий газарт бэлдэц тээвэрлэдэг авто машины жолоочийн замын хуудсыг хөтлөөгүй, нийт 10.5 сая төгрөгийн шатахууны тооцоог бодоогүй, бараа материалын дансаар дамжуулалгүй, шууд зардлаар тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7-т "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: авто машины жолоочийн замын хуудсыг хөтлүүлэн, шатахууны тооцоог бодож, бараа материалын дансаар дамжуулан бүртгэж байх.

5. Цалингийн нэмэгдэл, төрийн хэмнэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт 11. Албан хаагчдын цалинд 1.4 сая төгрөгийн ярианы төлбөрийн нэмэгдлийг тооцож олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.1-т "үндсэн үйл ажиллагаа нь шуурхай албаны болон бэлэн байдлыг хангах чиг үүрэгтэй этгээдийн албаны гар утасны зардлаас бусад гар утасны зардал", 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Албан хаагчдын цалинд ярианы төлбөрийн нэмэгдлийг тооцож олгохгүй, зөвхөн шуурхай албаны болон бэлэн байдлыг хангах чиг үүрэгтэй этгээдийн албаны гар утасны зардлыг байгууллагаас төлөх.

6. Бэлэн мөнгөний кассын зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт 12. Тайлант хугацаанд кассаас зарим ажилчдын цалин, материал худалдан авах, өр төлбөр төлөх гэх мэт 371.8 сая төгрөгийн бэлэн мөнгөний зарлагын гүйлгээ хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын үйл ажиллагааны зарлагын гүйлгээг бэлэн мөнгөөр хийхгүй байх.

7. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт 13. Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК шилэн дансны бие даасан цэс байхгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 22,046.5 сая төгрөгийн орлогын 16 гүйлгээ, 20,705.8 сая төгрөгийн зарлагын 73 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 1.7 сая төгрөгийн 2 шийдвэрийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3.1-д "Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна" 3.1.1-д "төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд"; 5.1-д "Байгууллага нь шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудсаар хүргэх бөгөөд цахим хуудас нь дараах шаардлагыг хангасан байна.": 5.1.1-т "шилэн дансны бие даасан цэстэй байх.": 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсыг нээлгэж, байршуулах мэдээллийг хууль, журамд заасан хугацаанд бүрэн байршуулж ажиллахыг зөвлөж байна.

8. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт 14. Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК нууцын зэрэгт хамаарахгүй 174.7 сая төгрөгийн бараа материалын худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол

төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 8 дугаар зүйлийн 8.5-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, журмыг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөж байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал

Аудитаар нийт 195.2 сая төгрөгийн алдаа³ илэрснээс аудитын явцад 195.2 сая төгрөгийн 12 алдааг залруулсан байна.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК	3	10,335.5	-	-	3	10,335.5	3	10,335.5	-	-	-	-
Баянхонгор аймгийн УБХ	1	173.4	-	-	1	173.4	1	173.4	-	-	-	-
Дархан-Уул аймгийн УБХ	1	144,985.9	-	-	1	144,985.9	1	144,985.9	-	-	-	-
Дундговь аймгийн УБХ	1	5,323.0	-	-	1	5,323.0	1	5,323.0	-	-	-	-
Орхон аймгийн УБХ	2	1,861.5	-	-	2	1861.5	2	1,861.5	-	-	-	-
Төв аймгийн УБХ	4	32,558.2	-	-	4	32,558.2	4	32,558.2	-	-	-	-
Дүн	12	195,237.5	-	-	12	195,237.5	12	195,237.5	-	-	-	-

Аудитаар нийт 35,936.4 сая төгрөгийн зөрчил⁴ илэрснээс, 51.7 сая төгрөгийн 6 төлбөрийн акт тогтоож, 162.8 сая төгрөгийн 8 албан шаардлага хүргүүлж, 35,721.9 сая төгрөгийн 21 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Улсын бүртгэлийн ерөнхий газар /төв аппарат/	9	31,597.1	1	2,586.0	3	29,011.1	5	-	-	-

³ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

⁴ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Төрийн үнэт цаас хэвлэл ТӨҮГ	10	35,808,695.0	2	47,333.9	2	118,939.9	6	35,642,421.2	-	-
Нийслэлийн УБГ	4	10,577.3	-	-	-	-	4	10,577.3	-	-
Архангай аймгийн УБХ	1	3,326.5	-	-	1	3,326.5	-	-	-	-
Булган аймгийн УБХ	3	65,442.5	1	326.6	1	3,849.5	1	61,266.4	-	-
Говьсүмбэр аймгийн УБХ	1	-	-	-	-	-	1	-	-	-
Дархан-Уул аймгийн УБХ	3	6,513.1	-	-	-	-	3	6,513.1	-	-
Орхон аймгийн УБХ	3	2,575.7	2	1,400.7	-	-	1	1,575.0	-	-
Сэлэнгэ аймгийн УБХ	1	7,700.4	-	-	1	7,700.4	-	-	-	-
Дүн	35	35,936,427.6	6	51,647.2	8	162,827.4	21	35,721,953.0	-	-

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 42,999.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 1 албан шаардлага хүргүүлж, 42,999.5 сая төгрөгийн 5 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<i>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</i>								
Төрийн үнэт цаас хэвлэл ТӨҮГ	1	42,753,971.6					1	42,753,971.6
Булган аймгийн УБХ	1	-			1	-		
Орхон аймгийн УБХ	1	70,848.0					1	70,848.0
Дүн	3	42,824,819.6			1	-	2	42,824,819.6
<i>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</i>								
УБЕГ /төв аппарат/	1						1	-
Төрийн үнэт цаас хэвлэл ТӨҮГ	1	174,707.5					1	174,707.5
Сүхбаатар аймгийн УБХ	1	-					1	-
Дүн	3	174,707.5					3	174,707.5
Нийт дүн	6	42,999,527.1			1	-	5	42,999,527.1